

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Ногооннуур сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БӨА-2024/171/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn	Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ж.Айгүл
Өлгий хот	Утас: 70422954 Цахим хаяг: aigulj@audit.gov.mn
2024 он	Аудитын менежер: Х.Женисбек Утас: 70422930 Цахим хаяг: jennisbekh@audit.gov.mn
	Аудитор: Р.Баярмаа Утас: 99265539 Цахим хаяг: bayarmaar@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	4
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	11
4. АУДИТЫН ТАЙЛАН	15
4.1 Ерөнхий зүйл	15
4.2 Материаллаг байдал.....	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
4.5.1 Завсрын аудитын талаар	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	17
5.1 Төлбөрийн акт	17
Төлбөрийн акт тогтоогдоогүй.	17
5.2 Албан шаардлага.....	17
5.3 Зөвлөмж	17
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	18

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



НОГООННУУР СУМЫН ЭРҮҮЛ
МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГА
К.АУКЕТАЙ ТАНАА

2024.02.23 № 179
танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ногооннуур сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Ногооннуур сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан 294.8 сая төгрөгийн Ховд багийн эмнэлгийн барилгыг хүлээн авч бүртгэсэн байна.

Аудитын гол асуудал

Эрүүл мэндийн төвийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд анхаарал татах асуудал байхгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

00402261

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж.АЙГҮЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Төгрөгөөр

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>331026267.9</u>	<u>265143812.5</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	169219561	64547336.37
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	169219561	64547336.37
3121	Төгрөг	169219561	64547336.37
31211	Төрийн сангийн харилцах	169219561	64547336.37
33	АВЛАГА	0	24802434
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага		24802434
35	БАРАА МАТЕРИАЛ	161806706.9	175794042.2
351	Түүхий эд материал	103978532.9	116594785.2
35130	Эм боох материал	103978532.9	116594785.2
354	Хангамжийн материал	46128174	59199257
35410	Бичиг хэргийн материал	1674310	2301410
35440	Түлш, шатах тослох материал	3865653	2584772
35460	Хүнсний материал	6676745	6437522
35470	Бусад хангамжийн материал	33911466	47875553
35600	Мал амьтад	11700000	0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1224230111</u>	<u>1541868576</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1224230111	1541868576
391	Газар	0	0
392	Биет хөрөнгө	1195185711	1507115176
39201	Барилга, байгууламж, орон сууц	1130131212	1424907312
39202	Хуримтлагдсан элэгдэл	-126746727.8	-162751438.6
39203	Авто-тээврийн хэрэгсэл	147246429	192276429
39204	Хуримтлагдсан элэгдэл	-101000148.7	-108860178.8
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	348582360.5	314632682.7
39206	Хуримтлагдсан элэгдэл	-237297396.1	-190372874.9
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	74698810	82955512
39208	Хуримтлагдсан элэгдэл	-40788327.78	-45848767.14
39209	Зам, гүүрийн байгууламж	233000	0
39210	Хуримтлагдсан элэгдэл		
39214	Бусад үндсэн хөрөнгө	866732	340000
39215	Хуримтлагдсан элэгдэл	-866732	-289999.98
39217	Ном	126500	126500
393	Биет бус хөрөнгө	29044400	34753400.03
39301	Програм хангамж	550000	1430000
39302	Хуримтлагдсан элэгдэл	-550000	-714999.97
39303	Бусад биет бус хөрөнгө	29044400	34038400
39304	Хуримтлагдсан элэгдэл	0	0

Ногооннуур сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1555256378.98	1807012388.90
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0.00	0.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1555256378.98	1807012388.90
51	Засгийн газрын хувь оролцоо	1555256378.98	1807012388.90
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	699896598.00	704890598.00
51101	Өмч: - төрийн	699896598.00	704890598.00
512	Хуримтлагдсан үр дүн	120456759.50	369268868.42
51210	Өмнөх үеийн үр дүн	120456759.50	122506858.50
51220	Тайлант үеийн үр дүн		246762009.92
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	734903021.48	732852922.48
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1555256378.98	1807012388.90

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,132,881,962.29	1,489,732,838.65
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	125,288,172.29	418,081,631.28
120	Нийтлэг татварын бус орлого	89,683,355.49	418,081,631.28
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	89,683,355.49	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	89683355.49	
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	-	409,227,927.28
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	-	8,853,704.00
122	Тусламжийн орлого	35,604,816.80	-
122001	Хандив тусламж /дотоод/	35604816.80	0.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,007,593,790.00	1,071,651,207.37
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	10,000,000.00	-
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	10000000.00	0.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	320,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	320000.00	0.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	26,340,700.00	27,104,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	26340700.00	27104700.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	970,933,090.00	1,044,546,507.37
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	970933090.00	1044546507.37
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	915,888,771.15	1,242,737,828.73
21	УРСГАЛ ЗАРДАЛ	915,888,771.15	1,242,737,828.73

Ногооннуур сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	915,888,771.15	1,242,737,828.73
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	565,706,728.93	751,786,406.00
210101	Үндсэн цалин	355670644.00	536222904.00
210102	Нэмэгдэл	105722084.93	148264402.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9369000.00	10462000.00
210104	Урамшуулал	47784975.00	56837100.00
210105	Гэрээт ажлын хөлс	47160025.00	0.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	72,212,875.28	94,042,197.00
210201	Тэтгэврийн даатгал	72212875.28	94042197.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	18,999,954.00	24,405,281.00
210301	Гэрэл, цахилгаан	2463624.00	4164628.00
210302	Түлш, халаалт	16536330.00	20240653.00
2104	Хангамж, бараа материалын зардал	67,739,611.84	106,237,063.00
210401	Бичиг хэрэг	2311670.00	3000900.00
210402	Тээвэр, шатахуун	52982000.00	76998270.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	42000.00	2593780.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		898500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5993360.00	12987380.00
210408	Бараа материал акталсны зардал	6410581.84	9758233.00
2105	Нормативт зардал	82,465,986.53	125,691,563.71
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	59922718.23	79884440.71
210502	Хоол, хүнс	22543268.30	45807123.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,404,620.00	899,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	87000.00	94000.00
210604	Урсгал засвар	4317620.00	805000.00
2107	Томилолт, зочны зардал	1,128,000.00	2,520,000.00
210701	Гадаад албан томилолт	-	-
210702	Дотоод албан томилолт	1128000.00	2520000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,476,890.00	1,326,226.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	600000.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	213450.00	54450.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	82440.00	162000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	66000.00	0.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1961000.00	810500.00
210807	Газрын төлбөр	280000.00	299276.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	274000.00	0.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	99,754,104.57	135,830,092.02
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1052400.00	1818700.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	98701704.57	134011392.02

Ногооннуур сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	216,993,191.14	246,995,009.92
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	-
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	233,000.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	0.00	233000.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(233,000.00)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	216,993,191.14	246,762,009.92

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1039263790.00	1046848773.37
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1039263790.00	1046848773.37
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	320000.00	0.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	320000.00	0.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	26340700.00	27104700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	26340700.00	27104700.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	1012603090.00	1019744073.37
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1012603090.00	1019744073.37
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	818041229.00	1113860068.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	818041229.00	1113860068.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	818041229.00	1113860068.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	562699133.00	751897803.00
210101	Үндсэн цалин	341461463.00	513303791.00
210102	Нэмэгдэл	120000225.00	166942895.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	8285000.00	10795000.00
210104	Урамшуулал	44818951.00	60856117.00
210105	Гэрээт ажлын хөлс	48133494.00	0.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	72175100.00	93930800.00
210201	Тэтгэврийн даатгал	46780800.00	63706100.00
210202	Тэтгэмжийн даатгал	6957900.00	7557300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4750600.00	6037800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1285200.00	1505600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	12400600.00	15124000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	22734400.00	23498400.00

Ногооннуур сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210301	Гэрэл, цахилгаан	4734400.00	5498400.00
210302	Түлш, халаалт	18000000.00	18000000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	58069550.00	81800250.00
210401	Бичиг хэрэг	2507200.00	3328000.00
210402	Тээвэр, шатахуун	48512100.00	64179670.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	42000.00	2593780.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	283800.00	1649700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6724450.00	10049100.00
2105	Нормативт зардал	84661539.00	133065089.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	65155159.00	91919089.00
210502	Хоол, хүнс	17732230.00	25778000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1774150.00	15368000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11173990.00	21525700.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2409800.00	2089000.00
210604	Урсгал засвар	8764190.00	19436700.00
2107	Томилолт, зочны зардал	1128000.00	2520000.00
210702	Дотоод албан томилолт	1128000.00	2520000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3911413.00	1626226.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	600000.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	213450.00	54450.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	82440.00	162000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	66000.00	0.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2055523.00	810500.00
210807	Газрын төлбөр	280000.00	299276.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	0.00	0.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	614000.00	300000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1488104.00	3995800.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1488104.00	3995800.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>221222561.00</u>	<u>-67011294.63</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	<u>52003000.00</u>	<u>37660930.00</u>
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	<u>52003000.00</u>	<u>37660930.00</u>
2200	Дотоод эх үүсвэрээр	<u>52003000.00</u>	<u>37660930.00</u>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	52003000.00	37660930.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-52003000.00</u>	<u>-37660930.00</u>
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>0.00</u>	<u>0.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	169219561.00	-104672224.63
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	169219561.00

Ногооннуур сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	169219561.00	64547336.37
----	---	--------------	-------------

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Төгрөгөөр

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	699,896,598.00	734,903,021.48	-96,536,431.64		1,338,263,187.84
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	699,896,598.00	734,903,021.48	-96,536,431.64	0.00	1,338,263,187.84
C07	Тайлант үеийн үр дүн			216,993,191.14		216,993,191.14
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	699,896,598.00	734,903,021.48	120,456,759.50	0.00	1,555,256,378.98
D01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	699,896,598.00	734,903,021.48	120,456,759.50	0.00	1,555,256,378.98
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			2,050,099.00		2,050,099.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	699,896,598.00	734,903,021.48	122,506,858.50	0.00	1,557,306,477.98
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт		-2,050,099.00			-2,050,099.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	4,994,000.00				4,994,000.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					0.00
D08	Тайлант үеийн үр дүн			246,762,009.92		246,762,009.92
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	704,890,598.00	732,852,922.48	369,268,868.42	0.00	1,807,012,388.90

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		169219561.00
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1300914600.00	1151520998.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1300914600.00	1151520998.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1300914600.00	1151520998.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	817453200.00	751897803.00
210101	Үндсэн цалин	526,742,400.00	513,303,791.00
210102	Нэмэгдэл	168,524,200.00	166,942,895.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	11,132,000.00	10,795,000.00
210104	Урамшуулал	111,054,600.00	60,856,117.00

Ногооннуур сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210105	Гэрээт ажлын хөлс		
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	102181700.00	93930800.00
210201	Тэтгэврийн даатгал	69,483,600.00	63,706,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	8,174,600.00	7,557,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,539,600.00	6,037,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,634,900.00	1,505,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	16,349,000.00	15,124,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	23498400.00	23498400.00
210301	Гэрэл, цахилгаан	5,498,400.00	5,498,400.00
210302	Түлш, халаалт	18,000,000.00	18,000,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	98589500.00	81800250.00
210401	Бичиг хэрэг	3,780,100.00	3,328,000.00
210402	Тээвэр, шатахуун	78,916,300.00	64,179,670.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,770,000.00	2,593,780.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,198,700.00	1,649,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	10,924,400.00	10,049,100.00
2105	Нормативт зардал	152088100.00	133065089.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	99,477,400.00	91,919,089.00
210502	Хоол, хүнс	30,673,200.00	25,778,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	21,937,500.00	15,368,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	76328300.00	58306630.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	45,025,000.00	30,542,930.00
210602	Тавилга	8,572,000.00	8,327,000.00
210604	Урсгал засвар	22,731,300.00	19,436,700.00
2107	Томилолт, зочны зардал	4707900.00	2520000.00
210702	Дотоод албан томилолт	4,707,900.00	2,520,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5260100.00	2506226.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	600,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	213,600.00	54,450.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	583,000.00	162,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	66,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,242,500.00	1,690,500.00
210807	Газрын төлбөр	430,000.00	299,276.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,125,000.00	300,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	20807400.00	3995800.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	20,807,400.00	3,995,800.00
13	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1131695100.00	1046848773.37
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	27104700.00	27104700.00
132001	Орон нутгийн төсвөөс	27,104,700.00	27,104,700.00
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1104590400.00	1019744073.37
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,104,590,400.00	1,019,744,073.37
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		169,219,561.00

Ногооннуур сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		64,547,336.37
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ		
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	45.00	47.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	37.00	35.00
620003	Үйлчлэх ажилтан	7.00	7.00
620004	Гэрээт ажилтан		4.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	45.0	47.0
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	37.00	35.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	8.00	8.00
650010	Гэрээт ажилтан		4.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

Тайлант онд нэмэлт төсөв аваагүй байна.

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Ногооннуур сумын Эрүүл мэндийн төв нь сумын ард иргэдэд эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий байгууллага юм.

Тайлант онд "Засгийн газрын тогтоол, Эрүүл мэндийн сайдын тушаал холбогдох стандарт, удирдамж тогтоомжийг мөрдөж, үйлчлэх хүрээний хүн амд тусалж үйлчилгээний багцад заасан эрүүл мэндийн үйлчилгээг чанартай хүртээмжтэй, түргэн шуурхай, чирэгдэлгүй тасралтгүй үзүүлэх болон иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл зан үйлийг хэвшүүлэх" гэсэн зорилго дэвшүүлж ажилласан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Ногооннуур сумын Эрүүл мэндийн төв нь Эрүүл мэндийн тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын сангийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль бусад холбогдох хууль, тогтоомжуудын хүрээнд үйл ажиллагаагаа явуулдаг.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна.

Засгийн газрын 2023 оны "Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 241 дүгээр тогтоолоор төрийн албан хаагчдын цалингийн сүлжээнд үнэмлэхгүй хэмжээний өөрчлөлт орсон.

Ногооннуур сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Сангийн сайдын 2023 оны 65 дугаар “Хөтөлбөр батлах тухай” тушаалаар аккруэл суурьт УСНББОУС-ыг нэвтрүүлэх дунд хугацааны хөтөлбөрийг баталсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Ногооннуур сумын Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаанд 2023 онд аймгийн ЭМГ-аас шалгалт хийж, шалгалтын дүнгээр зөвлөмж өгсөн байна. Мөн Магадлан итгэмжлэлийн шалгалт хийгдэж 3 жилийн лицензийн эрх авсан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Ногооннуур сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэль сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Ногооннуур сумын Эрүүл мэндийн төвийн даргын 2017 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 29 тоот тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг мөрдөж ажилласан байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Ногооннуур сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 134.9 сая төгрөгөөр буюу 16.1 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	169,219.56	64,547.34	-104,672.22
Авлага	0.0	24,802.43	24,802.43
Урьдчилгаа	0.0	0.0	0.0
Бараа материал	161,806.71	175,794.04	13,987.34
Үндсэн хөрөнгө	1,224,230.11	1,541,868.58	317,638.46

Ногооннуур сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Нийт хөрөнгө	1,555,256.38	1,807,012.39	251,756.01
Өр төлбөр			
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,555,256.38	1,807,012.39	251,756.01
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,555,256.38	1,807,012.39	251,756.01

Мөнгөн хөрөнгө данс оны эцэст 64.5 сая төгрөг болж 104.7 сая төгрөгөөр буурсан байна.

Авлага данс оны эхэнд үлдэгдэлгүй ба тайлант онд ЭМД-ын сангаас авах 24.8 сая төгрөгийн санхүүжилтийн авлагыг бүртгэж тайлагнасан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 175.8 сая төгрөг болж оны эхнээс 13.9 сая төгрөгөөр өссөн байна. Эм боох материалын үлдэгдэл 116.9 сая, аж ахуйн материал 47.9 сая, хүнсний материалын үлдэгдэл 6.4 сая төгрөг, түлш шатах тослох материалын үлдэгдэл 2.6 сая төгрөг, бичиг хэргийн материал 2.3 сая төгрөг байна.

Төсвийн хөрөнгөөр 254.3 сая төгрөгийн материал худалдан авч, үнэ төлбөргүй 8.9 сая төгрөгийн бараа материал авсан байна. 2022 оны жилийн эцэст аймгийн Эрүүл мэндийн газраас 78.5 сая төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгслийг хүлээн авч орлогод авсан ба тухайн материал эм, эмнэлгийн хэрэгслүүд нь ашиглагдахгүй, хугацаа дуусаж байгаа тул зарцуулагдаагүй үлдэгдэлд байна.

Байгууллагын өмч хамгаалах зөвлөлийн дүгнэлт болон даргын тушаалаар нийт 9.8 сая төгрөгийн бараа материалыг акталж устгасан байна. Тайлант онд байгууллагын туслах аж ахуй болох мал /хонь/ -аас цаг агаарын байдал зудаас үүдэж 2.0 сая төгрөгийн мал хорогдсоныг сумын Мал эмнэлгийн улсын байцаагчийн дүгнэлт болон УЦУОШГ-ын мэргэжилтний тодорхойлолтод үндэслэн данс бүртгэлээс хассан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,541.9 сая төгрөг болж 317.6 сая төгрөгөөр өссөн байна. Төсвийн хөрөнгөөр 37.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авч, үнэ төлбөргүй 398.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгө хүлээн авсан байна. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан 294.8 сая төгрөгийн өртөг бүхий Ховд багийн эмнэлгийн шинэ барилгыг хүлээн авч бүртгэлд оруулсан байна.

ЭМЯ-аас 12.7 сая төгрөгийн тоног төхөөрөмж, Онцгой байдлын ерөнхий газраас 72.0 сая төгрөгийн автомашин, ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 18.8 сая төгрөгийн гал тогооны тоног төхөөрөмжийг хүлээн авсан байна. Ховд багт баригдсан болон Улаанчулуу багт баригдаж байгаа эмнэлгийн эзэмшил газрын эрхийг аймгийн ИТХ-ын тогтоолоор 4.9 сая төгрөгөөр үнэлж биет бус хөрөнгө дансанд орлогод авч бүртгэлд тусгасан байна.

Аймгийн ИТХ-ын тогтоолоор 33.4 сая төгрөгийн хөрөнгийг акталж данснаас хасаж, элэгдлийн хугацаа нь дууссан 99.3 сая төгрөгийн анхны өртөгтэй үндсэн хөрөнгийг дахин үнэлж 10.99 сая төгрөгөөр бүртгэсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 251.8 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 251.8 сая төгрөг гарснаас шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Ногооннуур сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Тус байгууллагын 2023 оны анх батлагдсан төсөв 1,228.3 сая төгрөг байна. Үүнд: Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг Эрүүл мэндийн даатгалын сангаас 1,201.2 сая, орон нутгийн төсвөөс 27.1 сая, нийт 1,228.3 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр байна.

Тайлант оны батлагдсан төсвийг 72.6 сая төгрөгөөр нэмэгдүүлж 1,300.9 сая төгрөгөөр тодотгож баталсан байна

Анх батлагдсан төсвөөс цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардлыг 14.8 сая, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 1.9 сая, хангамж, бараа материалын зардлыг 24.5 сая, нормативт зардлыг 12.8 сая, эд хогшил, урсгал засварыг 3.7 сая, томилолтын зардлыг 2.3 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөрийг 0.5 сая, бараа үйлчилгээний бусад зардлыг 15.8 сая төгрөгөөр нэмэгдүүлж, нийт 72.6 сая төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна.

Төрийн албан хаагчдын цалин 2023 онд үнэмлэхүй хэмжээгээр нэмэгдсэнтэй холбоотой цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлуудыг нэмэгдүүлж тодотгосон байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэх эх үүсвэрийн хувьд 1,104.6 сая төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас, 27.1 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс бүрдүүлж, 169.2 сая төгрөгийг оны эхний үлдэгдлээс зарцуулахаар байна.

Гүйцэтгэлээр Эрүүл мэндийн даатгалын сангаас 1,019.7 сая төгрөгийн, орон нутгийн төсвөөс 27.1 сая төгрөгийн санхүүжилт авч, оны эхний үлдэгдлээс 104.7 сая төгрөгийг зарцуулж, нийт 1,151.5 сая төгрөгийн төсвөөр үйл ажиллагаа явуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,151.5 сая төгрөг буюу 88.5 хувьтай байна. Энэ нь Эрүүл мэндийн даатгалын сангаас авах санхүүжилтийг гүйцэтгэлээр 84.9 сая төгрөгөөр дутуу авсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	Эмнэлгийн тусламж үйлчилгээ				
1	Нэг иргэнд ногдох нормативаар	749.2	709.7	-39.5	94.7%
2	Үндсэн мэргэжлийн тусламж, үйлчилгээ	355.4	269.5	-85.9	75.8%
3	Дээд шатны төсвөөс хуваарилсан	169.2	145.3	-23.9	85.9%
4	Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	27.1	27.1	0.	100%
	Дүн	1,300.9	1,151.6	-149.3	88.5%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Эрүүл мэндийн төв нь тайлант онд нэмэлт төсөв аваагүй байна.

Ногооннуур сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Ногооннуур сумын Эрүүл мэндийн төв 2023 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Ногооннуур сумын Эрүүл мэндийн төв нь 2023 онд батлагдсан төсвийн хүрээнд 254.3 сая төгрөгийн материал, 37.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Цэнгэл сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Р.Баярмаа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор Ж.Айгүл нар хэрэгжүүлсэн.

Ногооннуур сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 03 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Ногооннуурын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 915.8 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 9.2 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгах асуудлын хүрээнд тус байгууллагын үйл ажиллагаатай холбоотой шалгахаар төлөвлөсөн 33 шалгуур үзүүлэлтээр горим сорил хэрэгжүүлж, хэрэгжилтийг шалгаж шилэн дансны тухай хуулийг бүрэн хэрэгжүүлээгүй зөрчилд зөвлөмж өгөгдсөн.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх

Ногооннуур сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны мэдээллээс санхүүгийн тайлангийн аудитын программд орсон мэдээллийн хэрэгжилтийг шалгахад төсөв өмч, хөрөнгө зарцуулах 65.7 сая төгрөгийн 6 шийдвэрийг шилэн дансанд мэдээлээгүй, мэдээлсэн байдлын хэрэгжилт 75 хувьтай байна. Өмнөх оны аудитаар шилэн данстай холбоотой алдаа, зөрчил илрээгүй тул зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Ногооннуур сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийгдсэн. Алдаа зөрчил илрээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийтдээ 53.1 сая төгрөгийн зөрчил илэрсэн бөгөөд 0.3 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 0.8 сая төгрөгийн албан шаардлага өгч, 52.0 сая 1 заалт бүхий зөвлөмж өгөгдсөн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	280.5	1	280.5	100%
Албан шаардлага	1	799.8	1	799.8	100%
Зөвлөмж	1	52003.0	1	52003.0	100%
Нийт дүн	3	53083.3	1	53083.3	100%

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 9,988.0 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад, 9,988.0 мянган төгрөгийн алдааг залруулав. Үүнд аймгийн ИТХ-ын тогтоолоор Ховд, Улаан чулуу багийн эмнэлгийн эзэмшил газрын эрхийг 4,994.0 мянган төгрөгөөр үнэлж биет бус хөрөнгө дансанд орлогод авч бүртгэхдээ Санхүүгийн үр дүнгийн тайланд тайлант үеийн орлогыг 4,994.0 мянган төгрөгөөр бүртгэснийг орлогоос бууруулж, Засгийн газрын оруулсан капитал дансанд бүртгэж залруулав. Үүний үр дүнд тайланд үеийн үр дүн өөрчлөгдсөн болно.

Аудитаар нийтдээ 77.8 сая төгрөгийн зөрчил² илэрч 1.56 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, 76.3 сая төгрөгийн зөрчилд 2 заалт бүхий зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогдоогүй.

5.2 Албан шаардлага

Аудитаар 1,564.1 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага өгөв.

Баян-Өлгий аймаг дахь Сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2023 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 130/ШШ2023/00061 дугаар шүүгчийн захирамжийг үндэслэн нэг их эмчийн ажилгүй байсан хугацааны нөхөн олговорт нийт 1,564,076 төгрөгийг эрүүл мэндийн төвийн төсвөөс шилжүүлэн барагдуулсан байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг нөхөн төлүүлэх албан шаардлага өгөв

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Анхан шатны болон нягтлан бодох бүртгэл хөтлөлтэй холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт:

Дотоод албан томилолт, ажил үйлчилгээнд төлсөн 10069.1 мянган төгрөгийн гүйлгээг тооцооны данс дамжуулахгүйгээр шууд зардлаар бүртгэж тайлагнасан.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай 14 дүгээр зүйлийн 14.3.1, 14.3.2, 14.3.3, 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсгийн 20.2.6 дахь заалт, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлангийн аргачлал, заавартай нийцэхгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Дотоод албан томилолт, ажил үйлчилгээнд төлсөн зардлыг тооцооны данс дамжуулан бүртгэж тайлагнах, Сангийн сайдын тушаалаар баталсан төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлангийн аргачлал, зааврыг мөрдөж ажиллах.

2. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

2.1. Илрүүлэлт:

Төсөв өмч, хөрөнгө зарцуулах 65.7 сая төгрөгийн 6 шийдвэрийг шилэн дансанд мэдээлээгүй, мэдээлсэн байдлын хэрэгжилт 75 хувьтай байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т “..... төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр” гэснийг зөрчсөн ба нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

2.2 Өгсөн зөвлөмж:

Шилэн дансанд мэдээлээгүй төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, авлага үүсгэсэн 65,7 сая төгрөгийн 6 шийдвэрийг нөхөж байршуулан зөрчлийг арилгах, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор, зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5-т заасан хугацаанд буюу зөвлөмжийг хүлээн авснаас 30 хоногийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Багийн эмнэлгийн эзэмшил газрын эрхийг бүртгэхдээ алдаатай бүргэсэн	2	9,988.0			2	9,988.0	2	9,988.0				
Дүн	2	9,988.0			2	9,988.0	2	9,988.0				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Шүүхийн шийдвэрээр нэг их эмчийн ажилгүй байсан хугацааны нөхөн	1	1,564,1			1	1,564,1						

Ногооннуур сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

олговорт 1,564.1 мянган төгрөгийг эрүүл мэндийн төвийн төсвөөс шилжүүлсэн.												
Дотоод албан томилолт, ажил үйлчилгээнд төлсөн зарим шууд зардлаар бүртгэж тайлагнасан	1	10,691.2					1	10,691.2				
Дүн	1	12,255.3				1	1,564.1	1	10,691.2			

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах авлага үүсгэсэн 65.6 сая төгрөгийн 6 шийдвэрийг байршуулаагүй	1	65,656.1					1	65,656.1
Дүн	1	65,656.1					1	65,656.1
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн	1	65,656.1					1	65,656.1